


Дараах мэдээллүүдийг Япон хэлнээс орчуулсан болно.

2021 оны 5 сарын 20-ны өдрөөс

Гамшгаас хоргодох зааврын дагуу заавал хоргодох

Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон

Сэрэмжлүүлгийн түвшин		Гамшгаас хоргодох шинэ мэдээ	
5	 Байгалийн гамшиг үүссэн Үүсэх аюул нүмрөлсөн	Нэн яаралтай ※1 аюулгүй байдлаа хангах	Гамшгаас хоргодох хуучин мэдээ Байгалийн гамшиг үүссэнталаарх мэдээ (Үүссэн нь тодорхой болмогц зарлана)
~<Сэрэмжлүүлгийн түвшин 4-с өмнө заавал хоргодох>~			
4	 Гамшгийн эрсдэл өндөр	Гамшгаас хоргодох заавар ※2	Гамшгаас хоргодох заавар (яаралтай)
3	 Гамшгийн эрсдэлтэй	Өндөр настан зэрэг ※3 хүмүүс аюулгүй газарт хоргодох	Гамшгаас хоргодох зөвлөмж Гамшгаас хоргодоход бэлдэх
2	 Цаг агаарын байдал хүндэрсэн	Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)	өндөр настнуудыг нүүлгэн шилжүүлж эхлэх Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)
1	 Цаашид цаг агаарын байдал хүндрэх эрсдэлтэй	Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)	Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг)

Жич 1: Орон нутаг гамшгийн байдлыг бүрэн тогтоох боломжгүй тул сэрэмжлүүлгийн түвшин 5-ыг тухай бүрд зарлах албагүй.

Жич 2: Гамшгаас хоргодох зааврыг өмнө зарладаг байсан гамшгаас хоргодох зөвлөмжтэй ижил нөхцөлд зарлана.

Жич 3: Сэрэмжлүүлгийн түвшин 3 нь өндөр наснаас бусад иргэд ч мөн шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалд тохируулан арга хэмжээ авч, гамшгаас хоргодох бэлтгэлээ ханган, аюултай гэж үзвэл сайн дураараа гамшгаас хоргодох үе юм.

Сэрэмжлүүлгийн түвшин 5 нь аюулгүй газарт хоргодох боломжгүй, амь насанд аюул учрахуйц байдлыг илтгэнэ.
Сэрэмжлүүлгийн түвшин 5, нэн яаралтай аюулгүй байдлаа хангахыг зарлах хүртэл хүлээж огтхон ч болохгүй!

Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон.
Харин одоо сэрэмжлүүлгийн түвшин 4, гамшгаас хоргодох зааврын дагуу бүгд аюултай газраас хоргодно уу.

Хоргодоход хугацаа шаардагдах өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд сэрэмжлүүлгийн түвшин 3, өндөр настнууд хоргодох зааврын дагуу аюултай газраас хоргодно уу.